

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН САНХҮҮ, ХАНГАЛТ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА **Я.ГАНТӨМӨР**

БАТЛАВ:  
УХ4003 9129146

БАТЛАВ.  
"НЬЮ АРМСТРОНГ" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ  
**Х.БАТТОГС**

118260067 6285185

### ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2020 оны <sup>6</sup> дугаар сарын <sup>25</sup> -ны өдөр

Дугаар <sup>108</sup>

Улаанбаатар хот

#### Нэг. Гэрээний талууд

1.1. Энэхүү гэрээг нэг талаас "Онцгой байдлын ерөнхий газар", түүнийг төлөөлж тус газрын Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа Г.Бат-Эрдэнэ /цаашид "захиалагч" гэх/, нөгөө талаас НЬЮ АРМСТРОНГ ХХК, түүнийг төлөөлж тус компаний захирал Х.БАТТОГС /цаашид "гүйцэтгэгч" гэх, хамтад нь "талууд" гэх/ нар харилцан тохиролцож, Иргэний хуулийн 476-482 дугаар зүйл, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актыг баримтлан, дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

#### Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1. Энэхүү гэрээний зорилго нь захиалагчийн хүсэлтээр коронавируст халдвар (ковид-19)-ын голомттой, дэгдэлт гарсан гадаад улсаас ирсэн иргэн, коронавируст халдварын батлагдсан тохиолдлын хавьталыг тусгайлан сонгож холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тусгаарлах, ажиглалтад авах үед тэдний аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж, үйлчилгээ үзүүлэх, түүнтэй холбогдон гарах зардлыг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2.2. Гэрээний хугацаанд талуудын эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэгчийн эрх зүйн байдал /өмчлөгч, эзэмшигч/ өөрчлөгдсөн эсэхээс үл хамаарч энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

2.3. Захиалагч болон гүйцэтгэгч гэрээний үүргийг биелүүлэхдээ Монгол Улсын Шадар сайдын баталсан 2020 оны 12 дугаар сарын ... - ны өдрийн ... дугаар

Захиалагчийг төлөөлж ..... Гүйцэтгэгчийг төлөөлж Х.БАТТОГС



тушаалаар баталсан “Тусгаарлан ажиглалт болон гэрийн ажиглалтыг зохицуулах түр журам”-ыг баримтлан ажиллана.

### **Гурав. Захиалга хийх нөхцөл**

3.1. Захиалагч иргэнийг тусгаарлан ажиглах байранд байрлуулахаас ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэж, дараахь мэдээллийг гүйцэтгэгчид бичгээр хүргүүлнэ:

- 3.1.1. байр, хоолны төлбөр;
- 3.1.2. эхлэх болон дуусах огноо, цаг;
- 3.1.3. иргэний шинжилгээнд хамрагдсан тухай мэдээлэл;
- 3.1.4. хүний тоо /том хүн, хүүхэд/;
- 3.1.5. /VIP/ иргэн /зочин/ байгаа бол мэдэгдэх;
- 3.1.6. нэмэлт тусгай үйлчилгээ байгаа бол мэдэгдэх.

3.2. Захиалагч иргэнийг байрлуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гүйцэтгэгчид үнэ төлбөргүй ашиглуулахаар хүргүүлэх бөгөөд гүйцэтгэгч тухайн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эрх бүхий байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу байрлуулан ашиглана.

3.3. Гүйцэтгэгч талд техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл үйлдэж, талуудын эрх бүхий албан тушаалтан зохих журмын дагуу гарын үсэг, тэмдэг /тамга/-ээр баталгаажуулсан байна.

### **Дөрөв. Төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх нөхцөл**

4.1. Гэрээний нийт төлбөрийг талууд тооцоо нийлсний үндсэн дээр тухай бүр тооцно.

4.2. Иргэн дараагийн шатлалын эмнэлгийн байгууллагад шилжсэн тохиолдолд тусгаарлан ажиглаглалтанд байх хугацаанд гарсан зардлыг суутгаад үлдсэн төлбөрийг захиалагчид буцаан олгоно.

4.3. Энэхүү гэрээний төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 хоногийн дотор талууд тооцоо нийлж, гүйцэтгэгчийн харилцах ГОЛОМТ банкны 415118531 дугаар харилцах дансанд шилжүүлнэ.

### **Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

5.1. Гүйцэтгэгч дараахь эрхтэй:

5.1.1. Тусгаарлан ажиглаглалтанд байгаа иргэн эмх замбараагүй байдал үүсгэх, согтууруулах ундаа хэрэглэх, өрөө хооронд сэлгүүцэх, халдвараас сэргийлэх дэглэм зөрчих зэргээр бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөхүйц үйлдэл, эс үйлдэл гаргасан тохиолдолд хамгаалалтын ажилтан уг асуудлыг таслан зогсоохыг шаардаж, эрх бүхий байгууллага, захиалагчид даруй мэдэгдэж, шуурхай арга хэмжээ авахуулах;



5.1.2. Иргэн тусгаарлан ажиглагдах үедээ шашин шүтлэг, хоол хүнсний харшлаас шалтгаалсан нэмэлт үйлчилгээ авах тохиолдолд шаардлагатай хөрөнгийг нэмэгдүүлэн тооцох;

5.1.3. Гүйцэтгэгчийн эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх.

5.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

5.2.1. Халдвараас сэргийлэх дэглэмийн хүрээнд:

5.2.1.1. Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн акт болон тусгаарлан ажиглах байрны дотоод дүрэм, журам /бэлэн байдлын зэрэгт шилжсэн/, гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлэх;

5.2.1.2. Тусгаарлан ажиглах байрны халдвараас сэргийлэх нарийвчилсан зааврыг урьдчилан авч, бэлэн байдлыг ханган, иргэнд танилцуулж, хэрэгжилтийг хангах;

5.2.1.3. Тусгаарлан ажиглах байранд холбогдох мэргэжлийн байгууллагаар зөвшөөрөгдсөн, Монгол Улсад ашиглаж болох ариутгах, халдваргүйжүүлэх бодисын жагсаалтад бүртгэгдсэн, гар халдваргүйжүүлэх болон цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэх бодисын нөөц бүрдүүлэх;

5.2.1.4. Тусгаарлан ажиглах байрны өрөө тус бүрт ариун цэврийн цаас, гарын болон эдийн саван, аяга таваг угаагч шингэн, порлон, цэвэрлэгээ хийх хэрэгсэл /алчуур, угаалгын бодис, бээлий гэх мэт/, хогийн сав, хар өнгийн хогийн уут зэргийг бэлтгэн байршуулах;

5.2.1.5. Халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ, үйлчилгээ хийх нарийвчилсан хуваарь /цаг хугацаа, хариуцах эзэн г.м/-ийг гаргаж өрөө тус бүрт байрлуулсан байх;

5.2.1.6. Эмчийн байрлах өрөө, хувийн хамгаалах хэрэгслийг тайлах хэсэгт орох, гарахыг хориглосон байршлуудад анхааруулах тэмдэглэгээг хийх;

5.2.1.7. Тусгаарлан ажиглах байрны ажилтнуудыг хамгаалах хувцас, хэрэгслээр хангах;

5.2.1.8. Тусгаарлан ажиглах байрны өрөө тасалгаа, гал тогоо, ариун цэврийн өрөөг тусгай зориулалтын цэвэрлэгээний бодисоор цэвэрлэж, халдваргүйжүүлэх ажлыг энэхүү гэрээний 5.2.1.5-д заасан хуваарь, зааврын дагуу хийх;

5.2.1.9. Тусгаарлан ажиглагдаж буй иргэн байрлах хугацаанд “Тусгаарлан ажиглах болон гэрийн ажиглалтыг зохицуулах түр журам”-д заагдсан хориглосон эд зүйлс оруулахгүй байх;

5.2.1.10. Эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгуулах талаар тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах.



## 5.2.2. Хоол үйлдвэрлэлийн хүрээнд:

5.2.2.1. Захиалагчийн өгсөн зааврын дагуу хоолыг эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд өрөө өрөөнд нь түгээх;

5.2.2.2. Захиалагчтай тохиролцсон хоолны цэсийн дагуу хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд гарал үүсэл нь тодорхой, шинжилгээ баталгаажилтад хамрагдсан, эрүүл мэндийг дэмжсэн, шим тэжээллэг, амин дэмээр баялаг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг сонгох, бүтээгдэхүүн нийлүүлэх газартай урьдчилан гэрээ хийх, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэж, стандартын шаардлага хангасан агуулахад хадгалан, батлагдсан жор, технологийн дагуу хоол үйлдвэрлэл, үйлчилгээг явуулах бэлтгэлийг хангах;

5.2.2.3. Тусгаарлагдсан иргэний нэг хоногийн хоолны илчлэг, хэмжээнд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж, хэмжээг батлах тухай” А/74 дүгээр тушаалыг үндэслэл болгох;

5.2.2.4. Жишиг хоолны цэсийг үндэслэн, хоолны цэс, технологийн картыг боловсруулан, батлуулж, иргэнд харшилтай хүнсний зүйл, хориглосон хоолны мэдээллийг авч, хоолны цэсэнд тусгах;

5.2.2.5. Хоол үйлдвэрлэлийн хэсгээс ажиглах өрөөнд хоол зөөвөрлөх, хоолны хэрэгслийг гал тогоонд хүргэх болон хог хаягдлыг зөөвөрлөх чиглэл, орох, гарахыг хориглосон байршлуудад анхааруулах тэмдэглэгээ хийх.

## 5.3. Бусад

5.3.1. Тусгаарлан ажиглах байранд иргэн эрх бүхий ажилтан, алба хаагчийн шаардлагыг эсэргүүцэх, эс биелүүлсэн тохиолдолд хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч шийдвэрлэх;

5.3.2. Тусгаарлан ажиглалтанд буй иргэний зайлшгүй шаардлагатай эд зүйлээр хангах талаарх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад хүсэлтийг уламжлах;

5.3.3. Тусгаарлан ажиглагдаж буй иргэний эзэмшлийн тоног төхөөрөмж, эд зүйлсийн чанар, гэмтэл, түүнээс үүсэх үр дагаврыг хариуцахгүй;

5.3.4. Эрүүл мэнд, онцгой байдлын байгууллагын ажилтан, алба хаагчаас тусгаарлан ажиглах байрны үйл ажиллагаатай холбогдуулан тавьсан шаардлага, аливаа хүсэлтийг цаг хугацаанд нь шуурхай биелүүлж, туслалцаа үзүүлж, хамтран ажиллах бололцоотой бүхий л арга хэмжээг авах;

5.3.5. Иргэн байрлах үеэр саад болох засвар үйлчилгээ, сайжруулалт хийх ажлыг зөвхөн давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд хийхгүй байх;

5.3.6. Тусгаарлах байрыг 24 цагийн хяналттай камерын болон зарлан мэдээллийн системээр тоноглох;





5.3.7. Тусгаарлан ажиглах байранд иргэний үлдээсэн, мартсан эд зүйлсийг хадгалан тухайн иргэнд буцааж өгөх, эсхүл захиалагчид хүлээлгэн өгнө.

5.3.8. Гүйцэтгэгч энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

### **Зургаа. Захиалагчийн эрх, үүрэг**

#### **6.1. Захиалагч дараах эрхтэй:**

6.1.1. Захиалагч гүйцэтгэгчээс үйлчилгээний чанар стандарт, болон шаардлагатай бэлэн байдлыг шаардах;

6.1.2. Гэрээний үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээ, мэдээллийг шаардах, үйл ажиллагаанд хяналт тавих.

6.1.3. Энэхүү гэрээнд заасан бусад эрхийг.

#### **6.3. Захиалагч дараах үүрэгтэй:**

6.3.1. Монгол Улсын хууль тогтоомж бусад эрх зүйн акт, "Тусгаарлан ажиглалт болон гэрийн ажиглалтыг зохицуулах түр журам"-ыг сахин биелүүлэх;

6.3.2. Гэрээний хугацаанд гуравдагч этгээдээр гэрээт үйлчилгээг гүйцэтгүүлэх тохиолдолд тусгаарлан ажиглах байрны үйлчилгээний талаар нарийвчилсан мэдээллийг бичгээр өгөх, гуравдагч этгээдийн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцах;

6.3.3. Иргэн байрлахаас өмнө тусгаарлах өрөөний цэвэрлэгээ үйлчилгээ, бэлэн байдалтай биечлэн танилцах;

6.3.4. Энэхүү гэрээгээр хүлээсэн бусад үүргийг.

### **Долоо. Гэрээ цуцлах**

7.1. Захиалагч энэхүү гэрээнд заагдсан нөхцлүүдийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэгчийн санаачлагаар гэрээг цуцлана.


7.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тусгаарлан ажиглах байрны журмыг мөрдөөгүй нь тогтоогдвол захиалагч гэрээг цуцлана.

7.3. Гэрээг цуцлах талаар энэхүү гэрээнд заасан нөхцлийн дагуу талууд харилцан бичгээр мэдэгдэнэ.

### **Найм. Давагдашгүй хүчин зүйл**

8.1. Гэрээнд оролцогч талуудаас үл хамаарах байгалийн үзэгдэл, төрөөс явуулж буй бодлого /хууль, эрх зүйн акт/, нийгмийн хямрал зэрэг шалтгаанаар талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар 24 цагийн дотор бие биедээ мэдэгдэх үүрэгтэй бөгөөд түүний улмаас учирсан хохирлыг талууд хүлээхгүй.

### **Ес. Маргаан шийдвэрлэх, бусад**

Захиалагчийг төлөөлж ..... Гүйцэтгэгчийг төлөөлж  .....



9.1. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж талууд гэрээний үүргээ зохих ёсоор бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болно.

9.2. Гэрээгээр зохицуулаагүй талууд хоорондын үүссэн бусад харилцааг энэхүү гэрээнд заасан нөхцөл, зарчмын хүрээнд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

9.3. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд нэн тэргүүнд хэлэлцэн тохиролцон шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.4. Захиалагчийн төлөөлөгчийг байлцуулан иргэн байрлах өрөөнүүдийг цэвэрлэж, хүлээлгэн өгөх, хүлээлцсэн баримт үйлдэнэ.

9.5. Тусгай үйлчилгээ шаардсан иргэнд энэхүү гэрээний 3.1-т заасны дагуу тусгаарлан ажиглах байрны эрх бүхий ажилтанд урьдчилан мэдэгдэх бөгөөд тухайн иргэний мэдээллийг нууцлахад талууд анхаарна.

9.6. Гэрээний хугацаа дууссан, гэрээ цуцлагдсан нь талуудын төлбөр, хохирол төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

9.7. Талууд аль нэг талдаа санал гаргах, гэрээнд өөрчлөлт оруулах тухай саналаа зөвхөн бичгээр хүргүүлнэ.

#### **Арав. Гэрээ зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

10.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ талууд сахин биелүүлээгүйн улмаас нийгэмд болон иргэнд хохирол учирсан нь тогтоогдвол холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Санхүү, хайгалт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа

Г.Бат-Эрдэнэ


Хаяг: Партизан 6, Сүхбаатар Дүүрэг  
5-р хороо, Улаанбаатар Төв, Монгол Улс

Холбоо барих утас: 51-262489,

Цахим шуудан:  
obeg\_sankhuu@yahoo.com

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Нью Армстронг  
Захирагч:   
Х.Баттогс



Хаяг: БЗДWRэг 22-р хороо  
11-234 1001

Утас: 99666644

Факс: .....

Цахим шуудан:  
New.Armstrong.Bus.9966@gmail.com

Цахим хуудас: .....

Захиалагчийг төлөөлж ..... Гүйцэтгэгчийг төлөөлж

